



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 06 өдөр

Дугаар А/290

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэлд тусгах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271^{1.1.1}, 271^{1.1.12} дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 4.1.1 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Өмч хамгаалах байнгийн зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжсэн туузан дамжуургаар тээвэрлэгдэж байгаа зэсийн баяжмалаас дээж авах, хэмжигдэхүйц химийн элементийн агууламжийг тодорхойлох тоног төхөөрөмжийн иж бүрдлийг Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансад бүртгэх жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансаас Гаалийн ерөнхий газрын харьяа Орхон аймаг дахь гаалийн газрын балансад шилжүүлж, бүртгэлд тусгах хөрөнгийн жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөрөнгийг хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусгахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т даалгасугай.

3. Хөрөнгийг хүлээн авч, нягтлан бодох бүртгэлд тусган, гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглахыг Орхон аймаг дахь гаалийн газар /Б.Майдармаа/-т даалгасугай.

4. Уг тоног төхөөрөмжийг гаалийн хяналт шалгалтын зорилгоор ашиглахад хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт шалгалтын газар /Б.Даваасүрэн/-т, Гаалийн төв лаборатори /С.Цэрэнчимэд/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Б.АСРАЛТ

1439501 2909

Гаалийн ерөнхий газрын даргын
2022 оны 12 сарын 28-ны
өдрийн 1 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансад бүртгэх тоног төхөөрөмжийн жагсаалт

№	Бараа материал	Марк	Огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Татвар	Нийт үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	Төгрөгөөр/
1	Рентген флюоресцент төхөөрөмж	XRF Elemental analyzer TEXAS 400	12/1/2022	1	560,057,355.00	39,459,151.28	599,516,506.28	-	599,516,506.28	
2	Дээж авагч төхөөрөмж	SAHARA, SAIMO mild-belt Sampling system	12/1/2022	1	487,592,645.00	23,503,595.74	511,096,240.74	-	511,096,240.74	
НИЙТ										
						62,962,747.02	1,110,612,747.02	0.00	1,110,612,747.02	

Гаалийн ерөнхий газрын даргын
2022 оны 12 сарын 06 -ны
өдрийн А.1000 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн балансаас Гаалийн ерөнхий газрын харьяа Орхон аймаг дахь гаалийн газрын балансад шилжүүлэх тоног
төхөөрөмжийн жагсаалт

№	Бараа материал	Марк	Огноо	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Татвар	Нийт үнэ	Хуриглагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг	/төгрөгөөр/
1	Рентген флюоресцент төхөөрөмж	XRF Elemental analyzer TEXAS 400	12/1/2022	1	560,057,355.00	39,459,151.28	599,516,506.28	-	599,516,506.28	
2	Дээж авагч төхөөрөмж	SAHARA, SAIMO mild-belt Sampling system	12/1/2022	1	487,592,645.00	23,503,595.74	511,096,240.74	-	511,096,240.74	
	НИЙТ			2	1,047,650,000.00	62,962,747.02	1,110,612,747.02	0.00	1,110,612,747.02	